



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/37

Номгон

Барьцаа хөрөнгө чөлөөлөх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоол "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.9.1, 2.9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 22-ны 848 дугаар албан бичиг, Бууцагаан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 04-ний 1а/200,1а/201 дүгээр албан бичиг, Богд сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 02-ны 04 дугаартай албан бичиг, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 2024/25, 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 2024/17, 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 2025/02 дугаар дүгнэлтүүдийн дагуу хавсралтад туссан төсөл арга хэмжээний чанарын баталгааг чөлөөлөхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т үүрэг зөвшөөрсүгэй.

2.Барилга байгууламжийн гадна, дотор засал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны зэргийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, Бууцагаан сумын Засаг дарга (Х.Дагвадорж)-д, Богд сумын Засаг дарга (Л.Ганаа)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ



626010039

Аймгийн Засаг даргын ~~Х.Х.Х~~ ²⁰²⁶ оны 01 дүгээр сарын
...-ны өдрийн 1/07 дугаар
захирамжийн хавсралт



ЧӨЛӨӨЛӨХ БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Барьцаа хөрөнгийн дүн
1	2	3	4
1	Бууцагаан сумын хуучин сургуулийн засварын ажил	Түйн долгион ХХК	17,504,002
2	Богд сумын цэцэрлэгийн барилгын засварын ажил		12,432,698
3	Бууцагаан сумын төрийн байгууллагуудын дунд зам талбайн тохижилт хийх		7,960,000
	Нийт		37,896,700

___оОо___

